

СЭТГҮҮЛЧ С.ЦОГТСАЙХАНЫ БҮТЭЭЛ ДЭХ
СЭТГЭЛГЭЭНИЙ ШИНЭЛЭГ ХАНДЛАГУУД

Б.Галаарид*

* Монголын Сэтгүүлчдийн Эвлэлийн ерөнхийлөгч, магистр, докторант

Түлхүүр үг: С.Цогтсайхан, уран бүтээл, сонины сэтгүүлч, өөр өнцгөөс харах, угтан харах, зураглан өгүүлэх

Сэтгүүлч С.Цогтсайхан нь уран бүтээлийн гараагаа Монголын радиогоос эхэлсэн хэдий ч бичлэгийн арга барил, өнгө аясын хувьд яалтгүй сонины сэтгүүлч байжээ. Энэ нь 1991 онд хэвлэгдсэн анхны ном болох “Би дуугүй байж чадсангүй”-гээс нь тодорхой харагддаг.

С.Цогтсайхан нийтдээ гурван удаа ном гаргаж, сэтгүүл зүйн бүтээлүүдээ эмхтгэж чадсан учраас ихэнх бүтээл нь үлдэж хоцорчээ. Гэхдээ зарим бичвэрийнх нь он сар тодорхойгүй, дийлэнх бичвэр нь хэзээ, ямар сонинд анх хэвлэгдсэн мэдээлэл алга байгаа тул агуулгаас нь харж байж он цагийг баримжаалан тогтоохоос өөр аргагүй болж байна.

Хоёр дахь ном болох “Тарчлаан”-ыг нь “Интерпресс” хэвлэлийн газар 1999 онд хэвлэн гаргажээ. Энэ номд 1990-ээд оноос хойш бичсэн нийт 25 бичвэрийг гурван бүлэг болгон оруулсан байна.

Гурав дахь ном “Хонхны дуу” нь үндсэндээ түүний уран бүтээлийн бүрэн тайлан гэж хэлж болно. “Энэхүү номоо эрдэнэт биеийг минь төрүүлж өсгөсөн аав, ээждээ зориулж, төрийнхөө буянаар сэтгүүлч мэргэжил эзэмшсэнийхээ 20 жил, эх орондоо ардчиллыг

тогтоохын төлөө тэмцэж эхэлснийхээ 15 жилийн ойг тохиолдуулан уншигч танаа өргөн барья”¹ гэсэн хадмалыг номынхоо эхэнд залснаас ч энэ нь тодорхой байна.

“Хонхны дуу” эмхтгэл нийтдээ зургаан бүлэгтэй. Нэгдүгээр бүлэг “Бидний араншин”-д нь “Хотын ямаа”, “Хотын ямаа-2”, “Дарга мэргэжил” зэрэг 35 бичвэр орсны дийлэнх нь асуудал дэвшүүлсэн шүүмжлэлт өгүүлэл, зарим нь хөрөг таталбар, фельетон байна. “Албан тасалгааны цонхоор” нэртэй хоёрдугаар бүлэгт “Сармагчин-хүн-сармагчин-хүн...!”, “Арбатын гудамжны хүүхдүүд”, “Сохор нүдний нулимс” зэрэг 18 бичвэр орсон байна. Бичлэгийн төрөл зүйлийн хувьд энэ бүлэгт сурвалжлага, аян замын тэмдэглэл, мөн цөөн тооны орчуулга багтжээ. Тус эмхтгэлийн гутгаар бүлэг нь “Өршөө” нэртэй. “Тавилан”, “Хөх чоно, хөөрхий чоно”, “Өнгө ба мөнгө” зэрэг ихэвчлэн Монгол орны хувь заяаны төлөө сэтгэл зовнисон 9 бүтээл оржээ.

Дөрөвдүгээр бүлэг нь “Ирж яваа цаг” нэртэй. Монголд оронд шинэ тулгар тогтсон ардчиллыг өмгөөлж хамгаалсан агуулга бүхий “Ирж яваа цаг”, “Ардчилсан хүчний лидерүүдэд илгээх ил захидал”, “Хал нь гаднаа, хайр нь дотроо миний ард түмэн” зэрэг 13 бүтээл орсон байна.

“Би дуугүй байж чадсангүй” хэмээх тавдугаар бүлэгт “Албан тушаалын

хожоо буюу төөрсөөр төрөлдөө", "Нөгөө үнэн", "Ажил хаялт ба ноолуурын дайн", "Тарчлаан" зэрэг сэтгүүл зүйн нэр бүхий 25 бүтээл багтжээ.

Зургадугаар бүлэг нь "Хонхны дуу" нэртэй бөгөөд "Хонх" хамтлагийн түүх, "Бидний араншин", "Хөдөө арал", "Ирж яваа цаг" концертод орсон дуунууд, бусад дуу шүлэг, дурсамжаас бүтжээ. Мөн С.Цогтсайхантай хийсэн ярилцлагууд, өөрийнх нь зурсан зургууд, гэрэл зургийн цомог зэргийг багтааснаараа энэ ном сэтгүүлч, дууны үг ая зохиогч, улстөрч С.Цогтсайханы амьдрал, уран бүтээлийн дэлгэрэнгүй тайлан болж чаджээ.

С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлүүдэд дүн шинжилгээ хийх нь бидний ажлын гол зорилго учраас цаашид зөвхөн сэтгүүл зүйн бүтээлүүдийнх нь талаар ярих болно.

"Хонхны дуу" эмхтгэлийн зургадугаар бүлэгт буй "Бүдүүн саарал" шоглолыг оруулан тооцох юм бол энэ номд сэтгүүл зүйн нийт 105 бүтээл орсон байна. Гэхдээ энэ нь түүний сэтгүүлч мэргэжлээр ажилласан 20 жилийн бүтээлийн бүрэн цуглуулга гэж хэлж боломгүй байна. Учир нь "Талд асаасан лаа", "Бөөр алаг бөмбөг буюу МСДН-ынхан" зэрэг нийтлэлүүд дээрх гурван түүврийн алинд нь ч алга байгаагаас үзвэл сэтгүүл зүйн олон бичвэр энэ мэтчилэн орхигдсон байх магадлалтай юм.

Түүний бүтээлүүд 1990 оны ардчилсан хувьсгалтай зэрэгцэн бичигдэж эхэлсэн Монголын шинэ сэтгүүл зүйн түүхийн нэгээхэн хэсэг гэдэг утгаараа алдаа оноотойгоо цуг үнэт баримт, судалгааны чухал хэрэглэгдэхүүн болон үлдэх учиртай.

Монголын чөлөөт сэтгүүл зүй хэрхэн үүсч бий болсон түүхийг судална гэвэл МоАХ-ны анхны хэвлэл "Шинэ толь", "Ардчилал", МСДН-ын "Үг", МҮДН-ын "Үндэсний дэвшил", МЧХН-ын "Чөлөөт хөдөлмөр", Ногоон намын "Ертөнц" зэрэг олон олон сонины үүсэн байгуулагдсан, бэхжиж хөгжсөн түүхийг

судлах хэрэгтэй болно. С.Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлийг тал бүрээс нь бүрэн төгс судална гэвэл ардчилсан хувьсгалд салбараасаа анхдагчид болон зүтгэж байсан Санжаасүрэнгийн Баяр, С.Амарсанаа, Ц.Элбэгдорж, Г.Бадамсамбуу, Б.Эрдэнэбаатар, Нанж, Лхагва, Б.Галаарид, Ш.Мягмарсамбуу, Ч.Пүрэвдорж, Ж.Мягмарсүрэн, Б.Цэнд-доо, Ч.Чулуунбаатар зэрэг олон сэтгүүлчийн тухайн үеийн бүтээл, идэвх оролцооны түүхийг давхар судалж, харьцуулан үзэх шаардлагатай болно.

Чөлөөт хэвлэлийн үр хөврөлийг Монголд суулгахын төлөө эр зориг гарган зүтгэж, ардчилсан хүчний сэтгүүлчид гэдэг нэр зүүж, зарим утгаараа ихээхэн гадуурхагдаж явсан эдгээр цөөн буурай сэтгүүлчдийн түүхээ нь болсон Сосорбарамын Цогтсайханы сэтгүүл зүйн бүтээлд дүн шинжилгээ хийж, судалгааны эргэлтэд оруулах анхны оролдлого нь энэхүү ажил болж байна.

Өөр өнцгөөс харах С.Цогтсайханы чадвар. Сэтгүүл зүйн бүтээл уншигчдын сэтгэл зүрхэнд хүрэх эсэх, хүмүүсийн санаанд урт удаан хугацаагаар оршиж санаж сэрэхийн дохио болох эсэх нь сэтгүүлчийн ур чадвараас гадна, сэтгэлгээнийх нь онцлогоос хамаардаг. Тэгэхээр сэтгэлгээний онцлог нь сэтгүүлчийг уран бүтээлчийнх нь хувьд үнэлэх гол хэмжүүрийн нэг юм. Сэтгүүлч С.Цогтсайхан энэ тухайд өөлөх аргагүй уран бүтээлч байсан нь түүний дурын нийтлэл, хөрөг, фельетонуос харагдана.

Ж ишээ нь: тэрбээр 1988 онд бичсэн "Дунд хуруу" хэмээх хэмжээгээрээ бага ч утга агуулгын хувьд том бичвэртээ албан тушаалтныг томилохдоо ур чадвар, овсгоо самбааг нь урьтал болгохын оронд гэр бүлийн байдал, архи дарс уудаг эсэх зэрэг олон шалгуураар шүүсний эцэст номхон томоотой, хал балгүйг нь сонгодог бараг бичигдээгүй хууль болсон түгээмэл дутагдлыг шүүмжлэхдээ гарын таван хурууг гол

баатар болгожээ. Тэтгэвэртээ гарах болсон хэлтсийн даргын оронд тэр тавын нэгийг нь сонгохоор болно. Энэ үйл явц хэрхэн өрнөснийг С.Цогтсайхан ийн зураглажээ.

...Хэлтсийн дарга тэтгэвэрт гарах болж, гарын хуруу шиг таван сайхан ажилтныг бүр үймүүлж орхив. Учир нь тэр тавын нэгийг хэлтсийн даргын албан тушаалд томилох болсон юм.

Эрхий гуайг томилчихвол бусад нь барьцахгүй л дээ. Үгэнд нь ороод л явна. Эрхий бол бусадтайгаа нэг эгнээнд хутгалдаад байх биш, гэвч хөндийрч тасраад байх биш, ер нь удирдлагын албанд тохирох л хүн. Эрхийг хүмүүс "мэргэн" гэж нэрлэдэг нь талаар биш ээ. Хамаг л төвөгтэй нарийн асуудлыг шийдвэрлэж, гарын үсгээ зурж, өндгөн тамгаа дардаг, өөрөөр хэлбэл бүх хариуцлагыг нуруундаа үүрсэн эр.

Гэвч Долоовортой нийлж шил архины бөглөө мулталсан болохоор нэгэн хэсэгтээ өөдлөхгүй гэсэн үг. Долоовор гуай тийм муу хүн үү гэвэл тийм биш. Тэр бүх насаараа энэ хэлтэст зүтгэсэн юм. Их идэвхтэй, түргэн шалмаг хөдөлгөөнтэй, бусдад заавар зөвлөлгөө өгөх дуртай. Ажлын аль хэцүүг хийж, амь бие хайрлахгүй зүтгэдэг болохоор хэзээний л бэртчихсэн явна. Долоовор уг хэлтэст эрдэм номын хуудас эргүүлэн сөхөж, толгой норон гүйсэн тос даасан эр. Түүнийг хэлтсийн даргаар томилбол гайхах хүн үгүй. Гэвч цонхны муутуу цаас чичин цоолж, шунал тачаалын гал ноцоож явсан хэрэг нь өчигдөрхөн мэт яригдах авай.

Харин Дундаа гуай л тайван сууна. Тэр түрүүлж дуугарахыг "хөнгөднө" гэж үздэг юм. Бие лагс. Нуруу өндөр. Номхон зан, номой ааштай. Түүний сайн муу талыг цохоод хэлчих жишээгүй, бариад авах баримтгүй... Магтаад байх ч юу байх вэ. Хамгийн гол нь алдаа гаргаж яваагүй. Энэ чинь

л гавьяа. Эцэст нь хэлтсийн даргын тушаалд Дундаа гуайг томилж үймэрсэн хэдийн сэтгэлийг амраав...

С.Цогтсайханы "Дунд хуруу" фельетон асуудлыг өөр өнцгөөс харах, хөндөхийн сонгодог жишээ гэж хэлж болно. Сэтгэлгээний ур муутай сэтгүүлчид энэ сэдвээр бичих даалгавар авлаа гэхэд боловсон хүчнийг томилох асуудалд ийм ийм алдаа дутагдал байна гэж хуурай тоочих, хэн нэгнээс ярилцлага авах төдийгөөр хязгаарлана. Уншигчид ч тийм уйтгартай бичвэрийг анхаарахгүй, тоохгүй. Гэтэл С.Цогтсайхан хөндөж буй асуудлаа илүү сонирхууштай болгохын тулд гарын таван хурууг гол баатраа болгон, хуруу тус бүрийн алдаа оноо, зан төлвийг товчхон зураглаж, даргад тэнцэх тэнцэхгүйн учир шалтгааныг тодруулж өгчээ.

Хуруу болгоны цаана тодорхой хүний дүр амилж, нийтлэл маань бүхэлдээ боловсон хүчний сонголтын гаж хандлагыг тодруулан гаргасан байна. Нэгэнт асуудлыг чадварлагаар уран сайханжуулан дүрсэлж чадсан учраас энэхүү нийтлэл хүний сэтгэлд удтал хоногшиж, улмаар ардын аман зохиол шиг түгэх магадлал өндөр болжээ.

1989 онд бичсэн "Дарга мэргэжил" хэмээх нийтлэлийг ч гэсэн С.Цогтсайханы сэтгэлгээний бярыг тод харуулсан бүтээл гэж нэрлэж болно. Даргын албан тушаал мэргэжил болон удамшиж, дарга гэдэг тодорхой хэв шинжит дүр болж хувирсан тогтолцооны гажгийг илчлэн шүүмжлэхдээ тэрбээр дарга болсон ач хүү, эмээ хоёрын харилцан яриа хэлбэрээр нийтлэлээ бичжээ. Ингэхдээ мөн л товч, богино хэлбэрийг сонгож, том асуудлыг бага зайд багтаасан нь ганцхан мэдээ бичих гэж хэдэн хуудсаар нь нуршдаг сэтгүүлчдэд том сургамж болохоор байгааг уг нийтлэлийг уншсаны эцэст ойлгох болно.

- Хүү минь, чи сонс. Чиний өвөө дарга байсан. Муу аав чинь дарга. Одоо чи дарга боллоо. Олон дарга

бэлтгэсэн хөгшин миний үгийг сонс. Чиний эцэг миний л гараар хүмүүжсэн дээ. (бүгшүүлнэ)

- Эмээ, би яарч байна. Намайг хүмүүс хүлээж байгаа.

- Битгий яар, хүлээж л байг. Хүлээх ёстой юм.

- Яаж болдог юм бэ!

- Яарна гэдэг чиний эхний алдаа.

Дарга хүн яарч болдоггүй юм.

- Эмээ минь, хэлэх гэсэн юмаа хурдан хэлчих.

- Чи ийм байдлаар хол явахгүй. Дарга хүн биеэ авч явах урлаг эзэмшсэн байдаг юм.

- Би мэднэ ээ

- Чи юу мэднэ гэж?

- Архи, тамхи, авгай...

- Наад хэлдэг чинь даргын цагаан толгойны зөвхөн "а" үсэг, Дарга бол нарийн мэргэжил юм. Хэн бүхэн энэ ажлыг хийж чаддаггүй юм. Бурхнаас заяасан энэ хишгийг буянтай хүн эдэлдэг. Одоо гэрээсээ гарахдаа яаралгүй тайван явах хэрэгтэй. Сонсож байна уу? Харц дээшээ, нүд хагас аниатай, алхаа зөөлөн.

- Эмээ минь би яарч байна. Гүйж л таарна.

- Тэнэг гэдэг нь. Чи ер нь хар хурдаараа гүйж яваа дарга үзсэн үү?

- Ёстой гайхалтай.

- Дарга хүн гайхаж болдоггүй юм. Мэдэхгүй ч гэлээ, мэдсэн дүртэй байх хэрэгтэй.

- Энэ ч арай ... (амандаа исгэрч)

- Чи исгэрч байна уу? Дарга хүн исгэрч шүгэлдэж болохгүй...

Энд хэд хэдэн онцлогийг анзаарч болно. Нэгдүгээрт, дүрээ амьдруулах чадвар. Эмээ, ач хүү хоёрын харилцан ярианаас хэн хэнийх нь дүр тодорхой байна. Эмээ бол даргын эхнэр байсан, хүү нь дарга, одоо ач нь дарга болж буй хүн. Даргын талаар үе уламжилсан хэвшмэл ойлголттой хүн. Ач хүү хэдийгээр дарга болсон ч гэлээ залуу хүний хувьд мөнөөх хэвшмэл ойлголтын хүрэнээс хальж гарах тэмүүлэлтэй, эсрэг дүр. Эндээс дарга гэдэг албан

тушаалыг хэн нь хэрхэн хардгийг ямар нэгэн нэмэлт тайлбаргүйгээр ойлгож болно. Сэтгүүлч маань шинэ хуучин хоёрын зөрчлийн оргил цэгийг.

"Болохгүй болохгүй л гэх юм. Би чинь ингэхэд хүн юм байгаа биз дээ.

- Биш ээ! Чи дарга" хэмээн нийтлэлийн төгсгөлд хатгаж өгсөн нь оновчтой, хүчтэй болжээ.

Ингэхдээ хуучин нь шинийгээ ялах магадлал ч бас байгааг нээлттэй орхин бичвэрээ төгсгөсөн нь асуудал хэр ноцтой, урхагтайг сануулах сэрэл мэдэрэмжийн илэрхийлэл юм.

С. Цогтсайхан "Шивээс" нийтлэлээ 1988 онд бичжээ. Хоёрхон хуудас бяцхан нийтлэл. Эхлэл төгсгөл нь шивээсээ арилгуулахыг хүсч буй хүн, эмч хоёрын харилцан яриа. Дунд хэсэгт нь энд тэнд хамаа замбараагүй босгосон самбаруудын тухай өгүүлнэ. Энэхүү гурван хэсгээс бүтсэн бяцхан нийтлэлд С.Цогтсайханы асуудлыг өөр өнцгөөс харах чадвар мөн л хурц тодоор илэрчээ. Эхний хэсгийг аваад үзье.

- Эмч ээ! Юу ч гэх вэ дээ. Би гэдэг хүн залуу зандан байхдаа саваагүй-тээд биеэрээ дүүрэн үг үсэг шивж орхисон юм.

- Хохь чинь дээ

- Эмч минь, тэр үед тийм моод дэлгэрч байсан юм.

- Та тэгээд яах гэж яваа юм бэ?

- Арилгуулах гэсэн юм.

- Мэс засал л хийнэ дээ

- Тэг ээ, тэг. Яасан ч яах вэ. Надад айх юм алга.

- Аль вэ, та наад цамцаа тайлаа-дах, харъя

-Ямар цамц?

- Наад өмсөж яваа цамцаа тайлахгүй юу

- Үгүй ээ, би нүцгэн сууж байна шүү дээ

- Аан? Энэ чинь харин сонин байна. Та босоод ир дээ. Наадахыг чинь уншъя. Юу гэнэ вэ?, хү хүү хүн...

- Та гаргахгүй ээ, хэв муутай бичсэн юм. Би өөрөө тайлбарлаж өгье.

Хүзүүнээс доош "Хүн бүр бага балчраасаа" гээд шивсэн байгаа биз? Харин энэ хэвлийнээс дээхэнд бол "хир буртаг хүргэхгүй" гэж шивсэн байгаа юм.

- Ёстой гайхамшигтай байна. Та тэгээд нээрээн арилгуулах гэж үү?

- Тэгэхээс яах вэ. Уг нь өч төчнөөн будаг, шунх, бэх мэх гарздан бичсэн юмсан. Хүүхнүүд шоолоод явуулахгүй юм.

- За за, би танд тусалъя...

Шивээсээ арилгуулах гэсэн хүнийг цамцаа тайл гэж эмч хүснэ. Гэтэл тэр цээж нүцгэн сууж байгаа болж таарав. Эмгэнэл, инээдэм буюу трагедия, комедия хэмээх урлахуйн хоёр том төрлийг хэдхэн үгэнд багтааж чаджээ. Хамгийн гол нь нэгэн цагт хүн болгоны амны уншлага болж, заавал цээжлэх үүрэг авч, цээжилсэн эсэхийг нь шалгах нүсэр ажил орон даяар өрнөж байсан социалист өмчийг нүдний цөцгий мэт хайрлан хамгаалах тухай уриа лоозонгийн үгнүүдийг тэрээр цээжээрээ дүүрэн шивүүлснээсээ салахыг хүсч байна.

Хоёр дахь хэсэгт болохоор арвилан хэмнэхийн чухлыг ухуулж энд тэнд хамаа замбараагүй босгосон самбарууд хичнээн сая төгрөг "идэж" буйг тооцоолжээ.

- Самбар олон янз. Том хэмжээний тосон будгийн самбар 1000-2000 төгрөгөөр үнэлэгддэг. Дунджаар 3х2 метрийн хэмжээтэй самбар 300 орчим төгрөгөөр үнэлэгддэг гэнэ.

300 төгрөг ... Хагас сарын цалин, хавар намрын пальто, хүлээн авагч, хүүхдийн тэрэг... Больё, больё, өөр юм бодъё. Улсын хэмжээгээр миний тооцоогоор хичнээн самбар байгаа билээ? 100 мянга. Нэг самбар 300 төгрөг. Тэгвэл 100 мянган самбарын үнэ 30 сая төгрөг болж байна. 30 сая! Мянга мянган самбарын сая сая төгрөг. Энэ бол 72 айлын сууц тавыг барих хөрөнгө юм. Ингэхлээр дуслыг хураавал бараг орон сууцны нэг хороолол барьж болох хөрөнгө

хуримтлах байсныг бодож цөхөхгүй биз ээ...

Арвилан хэмнэхийг уриалж орон даяар босгосон самбар нь ийнхүү арвилан хэмнэхийн эсрэг үйл хэрэг болсон урвуу тогтолцоог сэтгүүлч соргог ажиж, дундач зардлыг тооцон түүгээр орон сууц босговол хичнээн айл тохилог байранд орж болохыг хэдхэн тоогоор хэлжээ.

Төгсгөл хэсэгт эргээд эмч, иргэн хоёрын харилцан яриа руу очно. Энэхүү тайлал хэсэгт сэтгүүлч хамгийн гол мессежээ харилцан яриа хэлбэрээр оруулж өгчээ.

- Эмч ээ, дуусах дөхөж байна уу?

- Тэвч. тэвч. Хүзүүн дээр чинь ганцхан "хүн" гэдэг үг үлдлээ.

- Наадхи үгээ үлдээчих

- Та тэртээ тэргүй хүн юм чинь илүү үгээр яах гэсэн юм. Арилгаж орхиё.

- Үгүй ээ, хүн гэсэн бичиггүй бол нэг л ойлгомжгүй. Үлдээчих.

Арвилан хэмнэхийн тулд үрэлгэн загнаж буйн учрыг ойлгохгүй толгой нь эргэсэн хүн эмчээс "Хүн" гэсэн бичээсийг арилгалгүй үлдээгээч гэж гуйж буйгаар нийгмийн гаж тогтолцооны эмгэнэл, инээдмийг ийнхүү тод томруун харуулж чаджээ. Энэ бол сэтгүүлч асуудлыг өөр өнцгөөс харж, илэрхийлэх чадварын бодит жишээ юм.

Угтан харах С.Цогтсайханы чадвар. С.Цогтсайхан хувь хүний хувьд яалтгүй цаг үеийн бүтээгдэхүүн хэдий ч өөрийн цаг үеийн уран бүтээлчдээс ялгарч чадсан нэг хүчин зүйл нь түүний ирээдүйг угтан харах бараг зөн билгийн гэмээр чадвар юм. Түүний нийтлэлүүдэд тухайн үедээ хийрхэл, сэтгэлийн хэт хөөрөл мэтээр харагдаж байсан олон санаа, сануулга цаг хугацаа улирахын хэрээр бодит үнэн болж хувирсаар байна. Энэ утгаараа тэрбээр өөрөө ч мэдэлгүй футурологч болсон гэлтэй. Футурологч гэж бодит баримт фактуудыг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх замаар ойрын болон холын ирээдүйд тухайн асуудал ямар өнгө

төрхтэй болохыг шинжлэх ухаанчаар угтан хэлдэг хүнийг хэлдэг. Ингэж угтан хэлэхэд логик сэтгэлгээнээс гадна ер бусын хурц зөн мэдрэмж ч бас тус болох нь бий.

С.Цогтсайханы ийм зөнч санаа нь өөрийнх нь бичсэн нийтлэлүүдээс гадна янз бүрийн цаг үед өгч байсан ярилцлагуудаас нь ч тод харагддаг. Тухайлбал, 1997 онд нэгэн сонинд өгсөн ярилцлагадаа “Миний ганц айж буй зүйл бол нүүрлэн буй төрийн дампуурал юм. Сүүлийн үед би улс орныхоо хувь заяаг хараар харах боллоо. Төрийн нэгдсэн зөв бодлогыг бус, зөвхөн эрх мэдэл, албан тушаалыг дээдлэн шүтсэн хүмүүс төрийн удирдлагад гарахыг эрмэлзэж, албан тушаалын төлөө үхэн хатан тэмцэлдэж байна. Учир нь албан тушаал бол өнөөдрийн монголчуудын амьжиргааны гол баталгаа болчихоод байна. Төрийн дампуурал, нийгмийн ялзралын үр дүнд иргэний дайн ч гардаг”, “Хүн аливааг сөнөөсөн шигээ бүтээж чаддаг байх ёстой. Тэгвэл монголчууд бидэнд ийм чадвар үгүйлэгдэж байна. Өнөөдөр бид дотоодын бараг бүх үйлдвэрүүдийг нурааж, өөрсдөө юу ч үйлдвэрлэхгүй байна. Харин оронд нь социализмаас авч байсан гуйлга, өр ширээ капитализмаас авдаг боллоо. Ийм улс орон хэзээ ч өөдөлж байгаагүй, нэгэн цагт модоо барьдгийг түүх гэрчилнэ”² гэсэн нь цөөхөн жилийн дараа, өнөөдөр улам ч хурцаар мэдрэгдэж байна.

С.Цогтсайханы нийтлэлүүд дэх ирээдүйг угтан харсан жишээг сонирхъя.

“Хөх чоно, хөөрхий чоно” нийтлэлээ С.Цогтсайхан 1997 онд бичихдээ “Сүсэг бишрэл чөлөөтэй болохын сацуу

хүмүүсийн аливаад сүржигнэх нь түймэр мэт аслаа” хэмээн өгүүлсэн нь өнөөдрийн байдлыг тэр үеийнхээс илүүтэйгээр хэлсэн зөнч өгүүлбэр юм.

Мөн 1997 онд “Ардчиллын баярыг тэмдэглэх өдөр ирнэ” гарчигтай нийтлэлээ тэрбээр:

“Талын Монголд нэгэн үйл явдал болоод найман жил өнгөрчээ. Тэр өдөр хэдэн залуус гар гараасаа барин үгээ хэлж, нэгэн дуу дуулж байсан юм. Хүмүүс түүнийг жирийн нэг цуглаан боллоо гэж үл тоож байсан. Харин тэр залуусын тэмцлийн үр дүнд өнөөдөр монголчууд тэс өөр хэв маягаар амьдрах болсноо тэр болгон мэддэггүй юм. Нэгэн суманд нэг хашаа барьж болно. Хотын төвд тэнгэр баганадсан байшин барьж болно. Даргыг халж болно. Хааныг алж болно. Харин бүхэл бүтэн

«

*С.Цогтсайхан хувь хүний хувьд
яалтгүй цаг үеийн бүтээгдэхүүн
хэдий ч өөрийн цаг үеийн уран
бүтээлчдээс ялгарч чадсан нэг
хүчин зүйл нь түүний ирээдүйг
угтан харах бараг зөн билгийн
гэмээр чадвар юм. Энэ утгаараа
тэрбээр өөрөө ч мэдэлгүй
футурологч болсон гэлтэй.*

»

нийгмийг өөрчлөнө гэдэг хэцүү бөгөөд аугаа. Тэгвэл өнөөдөр тэр аугаа их үйлсийн баяр болж байна. Алга ташаарай” гэж эхлээд ардчиллын баярыг улс түмний баяр гэж хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан эрх баригч МАХН-ыг хатуу үгээр шүүмжилж, энэ баярыг бүх нийтээр тэмдэглэх өдөр ирнэ гэсэн нь хэдхэн оны дараа биеллээ олсон байна.

2000 онд тархинд нь цус харвахаас хоёрхон хоногийн өмнө бичсэн “Уснаас цэвэр гарахгүй” гэсэн гарчигтай улс төрийн нийтлэлдээ тэрээр “Хэт цөөхөн хүн амтай, хэт олон намтай монголчууд маань хорь биш, хоёр л намд хуваагдъя. Дор бүрнээ нохойн наадам зохион байгуулж байхаар ардчиллаа хүрээлэх нь чухал байна” гэсэн нь ч хэрэг дээрээ Монголын ирээдүйг угтан

харсан зөнч бодлын илэрхийлэл юм. Монголчууд олон нам хөдөлгөөнд талцан хуваагдахын хэрээр, улстөр-бизнесийн аль болох олон бүлэглэлд хуваагдахын хэрээр асуудлаа шийдэх, хөгжлийн зөв гарцаа олох магадлал буурч байгаа нь өнөөгийн бодит үнэн. Гэхдээ үүнийг олон оны өмнөөс угтан харж хэлсэн нь цөөхөн билээ.

Зураглан өгүүлэх С.Цогтсайханы чадвар. С.Цогтсайхан 1997 онд "Хөх чоно, хөөрхий чоно" гэдэг нийтлэлээ бичжээ. Энэ нийтлэл ингэж эхэлдэг.

"Үхэл дагуулсан азарган чоно хөндийн салхинд сэрвээнийхээ үсийг сортолзуулан өндөр хадны эгц орой дээр оцойн суугаад хийморио дуудах мэт уртаар уянгалуулан улина.

Уйлаад ч байх шиг, дуулаад ч байх шиг. Өөрөө ч үхэх юм шиг, өрөөлийг ч алах юм шиг. Ямар ч байсан түүний салхин доороос үхэл үнэртэнэ. Нэг л зэвүүн. Нам гүмийн хөшгийг цуу татах шиг буун дуу тасхийхэд хийморлиг нэгэн амьтан уулын уруу шинэхэн цас будруулан өнхөрлөө.

Ингэж чонотой жил бүр зарладаг дайн эхэллээ. Энэ дайнд манай орны 300 гаруй сумын анчид буу шийдмээ агсан нэгэн зэрэг морддог юм.

Цайдам хөндий буун дуугаар цочирдсон, цагаан цас, улаан цусаар будагдсан чонын эсрэг их дайн болж байна. Энэ дайны цар хүрээ жилээс жилд нэмэгдэх болсон нь зах зээлийн давалгаа чоныг дайрсан хэрэг"

Чонын улианы тухай ийнхүү кино мэт зураглан өгүүлсэн мөрүүдийг гагцхүү уран зохиолоос л олж болно. Харин С.Цогтсайхан үүнийг сэтгүүл зүйн бүтээлдээ шигтгэж чадснаараа энгийн богино өгүүлбэрээр ихэвчлэн бичдэг зуршлаа эвдэж, уран сайхнаар зураглан өгүүлэхүйн мастер байж бас чадна гэдгээ нотолжээ.

Нийтлэлийн дунд хэсэгт чонын авд хэн дуртай нь хошуурах болсон, чоно улстөр, бизнесийн лоббины хэрэгсэл болсон, чонын бүх эд эрхтэн сайн гэсэн хийрхэл газар авсан, чоныг хил гаа-

лиар хууль бусаар гаргах болсон, энэ чигээрээ байвал Монгол улс өөрийнхөө тахийг гадаадаас авсан шигээ чоноо ч гуйж мэдэх талаар сэрэмжлүүлжээ. Ингэхдээ хүн, чоно хоёрын өчлийг цөөн үгээр шигтгэсэн нь оновчтой, хүчтэй өгөлт болжээ. Тухайлбал, чоно "Хүн чи өвс идэх чинь яалаа. Хүн сүрэг чамтай нохой мэт эвсэн нийлж чадаагүй минь эрх чөлөөний билээ тэмдэг болог" хэмээн өгүүлж буй нь үргэлж сайн сайхан, зэрэг зөвийн билэгдэл болгодог нохойг чонын нүдээр харж, түүний эрх чөлөөгүй хөөрхийлөлтэй байдлыг зурагласан гайхалтай бодрол юм. Энэ нийтлэлийн төгсгөл яалтгүй сонирхол татна. С.Цогтсайхан энд дан ганц чонын тавиланг төдийгүй, улс орны хувь заяаг ч түүхэн домогтой сүлэн ёрлосон гэмээр байна.

"Сэлэнгэ мөрний хөндий уруудаад нэгэн гичий чоно хурдлан харайлгана. Түүний араас шар өнгийн УАЗ-469 шил даран элджээ. Машинд суугаа гангамсаг эр жолоочоо шамдуулж:

- Буудаж болохгүй байна аа. Дайрчих гэж халамцуугаар тушаана.

- Бартаа ихтэй. Хамаагүй хурдалж болохгүй гэж жолооч хэлнэ.

Гангамсаг эр турьхан цагаан гартаа виски хүзүүдэн атгах бөгөөд түүнээсээ үе үе балган зоригоо чангална. Тэгснээ согтов уу гэлтэй гэнэт буугаа шүүрч аваад хаалгаа онгойлгохыг завдав. Чоно гүйдлээ займчуулсаар хэсэг ойн захад ойртож ирлээ. Энэ бол Монголын сүүлчийн чоно. Гангамсаг эрийн анхны зугаа.

- Зогс! гэж хашгирахад машин цас манарган огцом зогсов.

Залуу эр машинаас ухасхийн гарч ирээд буугаа онилж нэг буудлаа. Оносонгүй. Угсраад хоёр ч буудлаа. Энэ залуу ойворгон бизнесмен Монголын сүүлчийн чоныг буудаж буйгаа яахин мэдэх билээ. Тэгээд ч уг чоно сайн анчинд сар элдүүлэн байж алагдах хашир тул мөнгө архианаас өөр зүйл барьж үзээгүй нусгайгийн сум

яаж тусахыг гадарлаж л явлаа. Чоно харайхдаа хожуулын ард орж амжсан тул одоо нэгэнт цаашх зам аюулгүй болжээ.

Залуу эр түй гэж газар нулимж харь хэлээр халирмаар баахан хараал урсгаад,

- Виски! гэж чангаар орилов.

Хэвлийдээ бэлтрэгээ тээсэн монгол хөх гичий чоно сульдатлаа сунайсаар тэр шөнөдөө Монголын нутгаас гарчээ. Хил давснаа тэр яаж мэдэх билээ. Хил давуулснаа бид яаж мэдэх билээ.

Ингэж тэнгис далайг гаталж ирсэн Бөртэ чоно эргэж тэнгис далай руугаа одлоо. Монголын хийморийг тээсэн хөх чоно, хөөрхий чоно.

Энэхүү төгсгөл хэсэг нь С.Цогтсайханы зураглан өгүүлэх чадвараас гадна ирээдүйг угтан харах чадварын бас нэгэн жишээ болохыг ч үгүйсгэх аргагүй юм. Өнөөдөр гэхэд л говийн чоныг алахыг түр хориглочихоод байна.

С.Цогтсайханы зураглан өгүүлэх чадварыг тод томруунаар харуулж чадах бас нэг бүтээл бол Д.Нацагдоржийн "Шувуун саарал" өгүүллэгийн барилаар бичсэн "Бүдүүн саарал" хэмээх шоглол юм. Тэрээр энэхүү шоглолыг ганзагын наймаа ид цэцэглэж асан 1994 онд бичжээ. Энэ бол Хятадын хилийн боомт Эрээн хавиас "гахай" хэмээх бүдүүн шуудайгаар бараа бөөндөж дүүргэн Оросын Свердловск, Москва хүртэл галт тэргээр явах зуур түүнийгээ зарж мөнгө болгогч наймаачдын байр байдал, дүр төрхийг өгүүлсэн шоглол юм. Нэмэлт тайлбар, нарийн задаргаа хийхийг азнаж уг бүтээлээс эшлэе.

"1. Хөндий талын зэрэглээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. Хэдэн бондгор юм түүний дунд сүүмэлзэх нь яахан даруй танигдана. Замын-Үүд өртөөнд дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл, хурдан галт тэрэгний ирэх энэ газрын бахдал,

ойртон үзвэл хэдэн залуу пийжүү ууж байна.

2. Сүрэнхүү бүдүүн саарал гахайны амыг арайхийн тогтоон байж цахилгааныг татаад битүү скоочдож, дээр нь сандайлан тамхи татна. Ташаа нь тэвхийж бөөрөөрөө язарсан бүдүүн саарал гахай хоёр чихээ солбилзуулан хааяа нэг бариулаараа ханзарч, эзнийхээ сэтгэлийг бухимдуулна.

3. Энэ үед удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүний томыг магтах бөгөөд бүдүүн саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж ямар бараа хаанаас хэдээр бөөндөв гэж асууна. Сүрэнхүү бүдүүн саарлын толгойг илбэн, хэлж өгөхгүй гэнэ. Цугаар нэг зэрэг бүдүүн саарлын тухай яриа бололцоод оройн шар наранд зүг зүг хоёр гурваараа нийлэлцэн нэг юм босгохоор одоогооно"

С.Цогтсайханы "Бүдүүн саарал" шоглол 11 бичил хэсгээс бүтэх бөгөөд хэсэг бүр нь инээдэмтэй, уншсан хүний сэтгэлд удал хадгалагдах онцлогтой нь түүний зураглан өгүүлэх чадварын нотолгоо юм.

Ишлэл

¹ Цогтсайхан С. 2003. Хонхны дуу. УБ., 10 дахь тал.

² Цогтсайхан С. 1999. Тарчлаан. УБ., 3 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Батбаатар Ж. 2009. Практик сэтгүүл зүй. УБ.

2. Батбаатар Ж. 2008. Суурь сэтгүүл зүй. УБ.

3. Зулькафиль М. 2009. Сэтгүүлчийн ур чадвар. 1, 2-р боть.

4. Норовсүрэн Л. 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. Гутгаар дэвтэр.

5. Цогтсайхан С. 2003. Хонхны дуу. УБ.

6. Цогтсайхан С. 1999. Тарчлаан. УБ.

Резюме

В настоящей статье автор предпринял попытку проанализировать творчество известного монгольского журналиста, одного из первых "ласточек" демократической революции 1990 года С.Цогтсайхана. Его произведения занимают по-

чётное место в сокровищнице монгольской журналистики. Изыскный, лёгкий стиль С.Цогтсайхана, способность предвидеть развитие событий, красочное изображение фактов и реалий выгодно отличают его творчество от произведений других журналистов.